



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/151

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Шүдний бор машин 2ш (Баяннуур, Гурванбулаг) нийлүүлэгчээр шалгарсан “Био медикал инженеринг” ХХК-тай 29,080,000 (хорин есөн сая наян мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн аван данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Баяннуур сумын Засаг дарга (Б.Ёндон), Гурванбулаг сумын Засаг дарга (Б.Дэлгэр) нарт үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Био медикал инженеринг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Чинзориг)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010193

Аймгийн Засаг даргын 2026 оны  
02 дугаар сарын 26-ны/ний өдрийн  
А.И.С. дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногийн дотор	М.Батчимэг
2	Баталгаат хугацаа	24 сар	Б.Ёндон Б.Дэлгэр
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Б.Ариунболд
4	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд

--o00o--